**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 16 өдөр Дугаар А/242 Улаанбаатар хот

Хууль, норм, дүрэм, стандартын
хэрэгжилтийг хангуулах талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд хууль, стандарт, нормын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, нэгдсэн төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох нутгийн захиргааны болон бусад байгууллагуудад, удирдамжид заасны дагуу хамтран ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт, хэрэгжилт, үр дүнг иргэд, олон нийтэд сурталчлан таниулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс (Г.Хонгорзул)-т тус тус даалгасугай.

3.Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж, явц үр дүнг сар бүр танилцуулж ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга (М.Баяраа)-д үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

1110201035

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
...03 дугаар.....сарын ..16..-ны өдрийн
...А/242 дугаар..............захирамжийн
1 дүгээр хавсралт

# ХУУЛЬ, НОРМ ДҮРЭМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

## Нэг.Зорилго

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж стандарт, норм дүрмийг мөрдүүлэх, арга хэмжээний зохион байгуулалт, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, иргэдийг болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх.

## Хоёр.Хугацаа

2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл.

## Гурав.Хамрах хүрээ

Нийслэлийн хэмжээнд барилга, дэд бүтэц, байгаль орчин, хот нийтийн аж ахуй, худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа хамаарна.

## Дөрөв.Удирдлага зохион байгуулалт

- Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч нь энэхүү нэгдсэн арга хэмжээнд удирдлага зохион байгуулалтаар хангаж хяналт тавина.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь удирдамж, төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, үр дүнг олон нийтэд сурталчлан таниулна.
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Дүүргийн Засаг даргын Тамгын газар нар нь хоёрдугаар хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж биелэлт, үр дүнг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.
- Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар нь энэхүү нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, тээвэр, шатахуун зардлыг шийдвэрлэж, сургалтын танхимын болон бусад шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ.

## Тав.Үйл ажиллагаа

Дараах үндсэн дөрвөн төрлийн ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

| д/д | Арга хэмжээний төрөл | Хийгдэх ажил |
|---|---|---|
| 1 | Судалгаа шинжилгээ | Стандарт, нормын хэрэгжилт хангагдаж байгаа эсэх, түүнд сөргөөр нөлөөлж байгаа нөхцөл шалтгааныг тодорхойлж цаашид авах арга хэмжээний санал дүгнэлтийг гаргах. |
| 2 | Сургалт | Стандарт норм дүрмийн талаар иргэн, аж ахуй нэгж, мэргэжлийн байгууллагын инженер техникийн ажилтан албан хаагчдыг мэргэжлийн сургалт, арга зүйгээр хангах |
| 3 | Стандарт, норм, дүрмийн хэрэгжилт хангуулах | Зөвлөн туслах: Стандарт норм дүрмийг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад зөвлөмж, арга зүйгээр хангах |
| | | Хяналт шалгалт: Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, Гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх. |
| 4 | Олон нийтэд мэдээлэх | Оролцогч байгууллагууд хариуцсан ажлын явц, үр дүнг тогтмол мэдээлнэ. Өөрийн чиг үүрэгтэй холбоотой хууль, норм дүрэм, стандартын талаар контент (видео шторк, зурагт хуудас, гарын авлага...г.м) бэлдэж бүх төрлийн сувгийг ашиглан иргэд олон нийтэд мэдээлнэ. |

**Зургаа.Тайлагнах**

Арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг төлөвлөгөөнд заасан хугацаа, давтамжийн дагуу хариуцсан байгууллагын удирдлага Нийслэлийн Засаг даргын удирдах ажилтны шуурхай хуралд, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

--оОо--

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 10-ны өдрийн
А/242 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

ИРГЭДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ, АЯ ТУХТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ХУУЛЬ, НОРМ ДҮРЭМ,СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 03 дугаар сарын 09

Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | | Төсөв /сая.төг/ | Хугацаа сар/өдөр | | Хамаарах байгууллага | | Тайлагнах Хугацаа сар/өдөр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур | Тоо | | Эхлэх | Дуусах | Хариуцах | Хамтрах | |
| Нэг. Стандарт мөрдүүлэх үйл ажиллагаа | | | | | | | | | |
| 1.1. Чанарын удирдлагын тогтолцоо | | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн харьяа байгууллагуудад MNS ISO 9001:2016 Чанарын удирдлагын тогтолцоо шаардлага стандартыг нэвтрүүлэх | Стандартыг нэвтрүүлсэн байгууллагын тоо. | 21 | 320 000 000 | V/01 | XII/31 | НЗДТГ | - | XII/31 |
| 1.2. Байгаль орчин | | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, түүнд мөрдөх журмыг боловсруулан баталуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Батлагдсан журмын тоо | 1 | 10.000 | I/01 | XII/15 | НАОБТГ | - | XII/15 |
| 2 | Гэр хорооллын айл, өрхийг "MNS 5679:2022 Сайжруулсан хатуу түлш. Техникийн шаардлага" стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах ажлыг зохион байгуулна. | Стандартын шаардлага хангасан сайжруулсан түлш | 768,000тн | 38,300 | I/01 | XII/15 | НАОБТГ | - | XII/15 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Автомашины аккумлятор, хайбрид батарей түр хадгалах цэгийн стандарт шинээр боловсруулан батлуулах | Боловсруулсан стандартын тоо | 1 | - | VI/01 | XII/01 | НБОГ | ХСХГ | XII |
| 4 | Зуслангийн бүсийн хашааны стандартын төслийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | I/01 | XII/20 | НБОГ | ХСХГ | XII/10 |
| 5 | Төвлөрсөн хогийн цэгүүдэд ирж буй хог хаягдлыг дарж устгахад “UCS 1705A:2022 Хог хаягдлын устгалын стандарт, устгалын удирдамж” хотын стандартыг мөрдөж ажиллана. | Стандартын тоо | 1 | - | III | I/02 | ХТГ | ТББ | XII/30 |
| 6 | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх ажилд “UCS 1701A:2022 Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандартыг мөрдөж ажиллана. | Стандартын тоо | 1 | - | III | I/02 | ХТГ, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | ТББ | XII/30 |
| 7 | Хог хаягдлын менежмент бүлгийн хотын стандартыг сурталчлан таниулж нэвтрүүлэх | Тохижилт үйлчилгээний байгууллагын тоо | 2 | - | IV/03 | XI/10 | БЗД ЗДТГ | ХСХГ | XII/15 |
| 1.3. Хот тохижилт, ногоон байгууламж | | | | | | | | | |
| 1 | Архитектур төлөвлөлтийн даалгаварт 9 бүлгийн 38 хотын стандартыг салбар чиглэл бүрд тусгаж, хэрэгжилтийг хангуулна. | Тухай бүрд | - | - | III/15 | XII/31 | ХБХГ | ХСХГ | XII/31 |
| 2 | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах хогийн савны стандартын хэрэгжилтийг хангуулна | Хотын стандартын шаардлагыг хангасан хогийн сав | 50 | 25.000 | V | IX | УБЗАА ОБХХУХ | ХТГ | IX/01 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага хангуулна. | Хотын стандартын шаардлагыг хангасан дугуйн зам | 48500 м2 | 2,485,000 | VI | I/02 | УБЗАА-ЯДЗТХ | ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | XII/01 |
| 4 | Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага хангуулна. | Хотын стандартын шаардлагыг хангасан явган хүний зам | 25500 м2 | 2,800,000 | VI | I/02 | УБЗАА-ЯДЗТХ | ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | XII/01 |
| 5 | Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт тавих ерөнхий шаардлага хангуулна. | Хотын стандартын шаардлагыг хангасан усан оригluур | Тухай бүрд | - | VI | I/02 | УБЗАА-ЯДЗТХ | ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | XII/01 |
| 6 | Гадна мэдээллийн байгууламжид тавигдах ерөнхий шаардлага хангаагүй самбарыг буулгах | Хотын стандартын шаардлагыг хангаагүй мэдээллийн самбар | 30ш | 50,000 | VI | I/02 | УБЗАА-ЯДЗТХ | ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | XII/01 |
| 7 | Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага хангуулна. | Хотын стандартын шаардлагыг хангасан саравч сүүдрэвч | Тухай бүрд | - | VI | I/02 | УБЗАА-ЯДЗТХ | ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | XII/01 |
| 8 | Хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбарт тавих ерөнхий шаардлага хангуулна. | Хотын стандартын шаардлагыг хангасан хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбар | Тухай бүрд | - | VI | I/02 | УБЗАА-ЯДЗТХ | ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | XII/01 |
| 9 | Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага хангуулна. | Хотын стандартын | Тухай бүрд | - | VI | I/02 | УБЗАА-ЯДЗТХ | ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | XII/01 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шаардлагыг хангасан тоглоомын талбай | | | | | | | |
| | Ногоон байгууламжийн арчилгаанд тавих шаардлага хангуулна. | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж | 135 га | 13.8 тэрбум | VI | I/02 | УБЗАА | ДҮҮРГҮҮД-ИЙН ЗДТГ ХТГ ААНБ | XII/01 |
| 10 | Гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг үе шаттай нэмэгдүүлж, нэгдсэн удирдлагын автомат системд холбосон хотын стандартын хэрэгжилтийг хангуулна | Гэрэлтүүлгийн ажлын тоо | 150 | - | V | I/02 | УБЗАА | ДҮҮРГҮҮД-ИЙН ЗДТГ, ААНБ | XII/01 |
| 11 | Гадна хаяг, хаягийн байгууламжийн стандартыг хангуулах, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд зөвшөөрөлгүй байршуулсан, урагдсан, өнгө үзэмжгүй хаягийн байгууламжуудыг буулгах арга хэмжээ зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 1 | 4.0 | III/01 | V/10 | УБЗАА, ДҮҮРГҮҮДИЙ ЗДТГ | Хороод | V/01 |
| 12 | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн ногоон байгууламжийг арчлан хамгаалах, нөхөн сэргээхэд “UCS 0803B:2022 Ногоон байгууламжийн арчилгаанд тавигдах шаардлага”, “UCS 0802A:2022 Цэцэрлэгчийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны удирдамж” хотын стандартыг мөрдөж ажиллана. | Стандартын тоо | 2 | - | IV | I | ХТГ | ТББ | X/30 |
| 13 | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд “UCS 1704A:2022 Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамж” хотын стандартыг мөрдөж ажиллана. | Стандартын тоо | 1 | - | III | I/02 | ХТГ | ТББ | XII/30 |
| 14 | Зам талбайн үйлчлэгч нарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нормын хувцасны стандартыг хангуулна | Стандарт шаардлага хангасан хувцастай байх | 126 | 35.0 | III | XII/01 | СХДЗДТГ, ТЦҮ ОНӨААТҮГ | Ган-Үжин ХХК оёдлын үйлдвэр | XII/01 2024 |

<table>
<tr><td>15</td><td>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлыг хангасан худалдаа, үйлчилгээний байгууллагуудын судалгааг гаргаж, хүртээмжийг сайжруулах зөвлөмж боловсруулан хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.</td><td>Зохион байгуулсан арга хэмжээ, тоо</td><td>1</td><td>3.0</td><td>III</td><td>XII/01</td><td>ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ</td><td>ХөХҮХ, хороод, ТББ, ААНБ</td><td>XII/01</td></tr>
<tr><td>16</td><td>Инженерийн шугам сүлжээний засварын ажлын шаардлагаар ухсан зам талбайг нөхөн сэргээхдээ "Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага"-ыг хангаж ажиллана</td><td>Засварын ажлын дараа хотын стандартын шаардлага хангасан зам талбайн нөхөн сэргээлт</td><td rowspan="2">8</td><td rowspan="2">1400</td><td>III</td><td>XII</td><td rowspan="2">ОСНААУГ</td><td rowspan="2">Тендерээр шалгарах байгууллагууд</td><td>XII</td></tr>
<tr><td>17</td><td>Инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээний ажлын үед "Барилга замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага"-ыг хангаж ажиллана.</td><td>Иргэд аюул осолгүй зорчсон ажлын талбайн тоо.</td><td>III</td><td>XII</td><td>XII</td></tr>
<tr><td>18</td><td>Нийслэлийн төв гудамж талбайд авто зам дээр байрласан цэвэр, бохир усны шугамын түвшин тааруугүй болон муудсан худгийн тагийг нэг стандарттай болгож засварлах</td><td>Засварлах худгийн тоо</td><td>50</td><td>-</td><td>IV</td><td>XI</td><td>УСУГ</td><td>НАЗАГ, НХТГ</td><td>XI</td></tr>
<tr><td>19</td><td>Хотын төвийн хэсэг Энхтайвны өргөн чөлөөнд байрлах цэвэр, Бохир усны шугамын худгуудын тэмдэглэгээг нэг стандарттай болгох</td><td>Ижил хэмжээтэй болгох</td><td>200</td><td>-</td><td>IV</td><td>X</td><td>УСУГ</td><td>НХТГ</td><td>X</td></tr>
<tr><td>20</td><td>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цэвэр, бохир усны гадна худгийн люк тагны стандартын хэрэгжилтийг хангуулан хамтран ажиллах</td><td>Хотын стандартын шаардлагыг хангасан сургуулийн орчин</td><td>30</td><td>-</td><td>III</td><td>VIII</td><td>НБГ</td><td>УСУГ<br>ХҮА</td><td>VIII</td></tr>
</table>

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд 3*3 сагсан бөмбөгийн талбай байгуулахад чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлагыг мөрдөж ажиллана. | Стандартын тоо | 1 | - | IV | X | ХТГ | ТББ | X/30 |
| 22 | Стандарт шаардлага хангасан спортын барилга, байгууламж, спортын талбайг барих, шинэчлэх, засварлахад санал, зөвлөмж өгч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | Хамтран ажилласан байгууллага | 5 | - | IY/01 | XII/30 | БТСУХ, НБГ | НБТСГ | XII/25 |
| 23 | Соёлын үл хөдлөх дурсгалт өвд Хотын стандартын хэрэгжилтийг хангуулна. | Стандартын шаардлага хангасан соёлын үл хөдлөх дурсгал | 276 | - | IV/10 | IX/15 | НСУГ | - | IX/25 |
| 24 | Соёлын хөдлөх дурсгалд Хотын стандартын хэрэгжилтийг хангуулна. | Стандартын шаардлага хангасан соёлын хөдлөх дурсгал | 3440 | - | IV/10 | IX/15 | НСУГ | - | IX/25 |
| 25 | Баянгол дүүрэгт хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн гадна тохижилтын талбайн орчинд Ногоон байгууламж, Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, Иж бүрэн гудамж, Зорчигч тээврийн үйлчилгээ, Гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл бүлгийн хотын стандартын хэрэгжилтийг хангуулна. Үүнд:<br>1. Хүүхдийн тогтоомын талбай 14<br>2. Сургуулийн гадна орчин 2,<br>3. Гэрэлтүүлэг 16<br>4. Явган зам, талбай 249 м2, 20 шат<br>5. гадна орчны тохижилт 1 | Арга хэмжээний тоо | 35 | 2,306.00 | V/01 | XI/01 | БГД | ХСХГ, Хороод | XII/31 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | Багахангай дүүрэгт хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн гадна тохижилтын талбайн орчинд Ногоон байгууламж, Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, Иж бүрэн гудамж бүлгийн Хотын стандартын хэрэгжилтийг хангуулна. Үүнд:<br>1. Дүүргийн 1, 2 дугаар хорооны байр, орц, гэр хорооллуудыг стандартын хаягжилттай болгох<br>2. 1,2-р хороонд мод тарих, ногоон байгууламжийн хашаа, хайсыг нэмэгдүүлэх<br>3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн асалтын хувийг нэмэгдүүлэх, улирлын болон графикт үзлэг хийх, засвар үйлчилгээнд хяналт тавих<br>4. Гэр хорооллын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, шинэчлэх ажил 26,<br>5. Хүүхдийн тоглоомын талбай 12<br>6. Явган хүний зам Iталбай 200 м2,<br>7. Хашаа хайс 1900 м2. | Арга хэмжээний тоо | 43 | 158,00 | III | XII/01 | БХД ЗДТГ | Багахангай тохижилт ОНӨААТҮ Г | XII/10 |
| 27 | Багануур дүүрэгт цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн гадна тохижилтын талбайн орчинд Ногоон байгууламж, Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, Иж бүрэн гудамж бүлгийн Хотын стандартын хэрэгжилтийг хангуулна. Үүнд:<br>1. Багануур 1-р хорооны Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын талбай<br>2. Багануур 1-р хороо Баялаг хорооллын “А, Б” блокын гадна талбай<br>3. Багануур 1-р хороо Баялаг хорооллын “В” блокын гадна талбай<br>4. Багануур 3-р хороо Уурхайн нийтийн байрны гадна орчинд<br>5. Багануур 1-р хороо 13-18-р байрны дунд хүүхдийн тоглоомын талбай | Арга хэмжээний тоо | 6 | 1,780.60 | IV | IX | БНД ЗДТГ | НХОГ, Багануур тохижилт ААТҮГ | XII/10 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6. Багануур 5-р хороо Нарийн хэсгийн хүүхдийн тоглоомын талбай | | | | | | | | |
| 28 | Чингэлтэй дүүрэгт цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн гадна тохижилтын талбайн орчинд Ногоон байгууламж, Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, Иж бүрэн гудамж бүлгийн Хотын стандартын хэрэгжилтийг хангуулна. Үүнд:<br>1. 1 дүгээр хороо 35 дугаар байрны урд талын тохижилт<br>2. 2 дугаар хороо БХ 30 болон 28 дугаар байрны тохижилт<br>3. 3 дугаар хороо 19, 29 дүгээр байрны тохижилт<br>4. 5 дугаар хороо Баавгайтай цэцэрлэгт хүрээлэнгийн засварын ажил<br>5. 8 дугаар хороо Зүүн тасган 8 дугаар гудамж хүүхдийн тоглоомын талбай засварлах шинэчлэх<br>6. 18 дугаар хороо Яргайтын 33, 43 дугаар гудамжны явган зам, гудамж сайжруулах ажил | Арга хэмжээний тоо | 6 | 305.20 | IV | XI | ЧД ЗДТГ | ЧД хөрөнгө оруулалт, ОНӨТҮГ | IX/01 |
| 29 | Налайх дүүрэгт хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн гадна тохижилтын талбайн орчинд Ногоон байгууламж, Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, Иж бүрэн гудамж бүлгийн Хотын стандартын хэрэгжилтийг хангуулна. Үүнд:<br>1. Хүүхдийн тоглоомын талбай 6,<br>2. Сургуулийн гадна орчин 1,<br>3. Гадна биеийн тамирын талбай 1,<br>4. Авто зогсоол 1,<br>5. Тохижилтын ажил 6. | Арга хэмжээний тоо | 15 | - | III | XII/01 | НД ЗДТГ | ХСХГ, Хороодын ажлын алба | XII/10 |
| 30 | Сонгинохайрхан дүүрэгт хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн гадна тохижилтын талбайн орчинд Ногоон байгууламж, Нийтийн эзэмшлийн эд | Арга хэмжээний тоо | 24 | 169.119,00 | III | XII/01 | СХД НЗДТГ, НХААГ | НХОГ | XII/01 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгө, Иж бүрэн гудамж, Зорчигч тээврийн үйлчилгээ, Гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл бүлгийн хотын стандартын хэрэгжилтийг хангуулна. Үүнд:<br>1. Сургуулийн гадна орчин 4,<br>2. Цэцэрлэгийн гадна орчин 2,<br>3. Цэцэрлэгт хүрээлэн 2,<br>4. Автобусны зогсоол 10,<br>5. Гэрэлтүүлэг 525<br>6. Явган зам 3 байршилд<br>7. Соёлын ордны гадна орчин 1,<br>8. Хогийн сав 20. | | | | | | | | |
| 1.4. Инженерын дэд бүтэц, авто зам, зогсоол | | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн авто замын санхүүжилтээр хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах үе шатны ажилд холбогдох стандарт норм дүрмийг хэрэгжүүлэн. | MNS-3<br>БНБД-3<br>БД-2 | 56 | - | III/01 | XII/01 | НЗХГ | – | Жилд 1 удаа |
| 2 | "UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага" Хотын стандартын шаардлагыг хангасан авто зам, зогсоолыгыг шинээр нэмэгдүүлж, авто замын засварыг хийсэн байна. | Хотын стандартын шаардлагыг хангасан авто зам, зогсоолын тоо | 1 | 480.0 | IV | XI | НЗХГ | БНД ЗДТГ | XI |
| 3 | Хотын бохир ус цэвэрлэх байгууламжуудаас гарах цэвэршүүлсэн хаягдал усыг стандарт хангуулах | Стандартын шаардлага нийцсэн цэвэршүүлсэн хаягдал ус нийлүүлсэн цэвэрлэх байгууламжийн тоо | 6 | - | III | I/02 | УСУГ ОНӨААТҮГ | - | XII |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Ус бохирдуулагч үйлдвэр, аж ахуйн нэгжүүдээс гарах хаягдал бохир усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны стандарт хангуулна. | Стандартын шаардлага хангасан бохир ус нийлүүлэх үйлдвэр, аж ахуйн нэгжийн тоо | 475 | - | III | I/02 | УСУГ ОНӨААТҮГ | БХБЯ УБЗАА ММСС | XII |
| 5 | Шинээр ашиглалтад орох барилга, байгууламжийн гадна бохир усны худаг, шугамын холболтыг стандарт, БНбД хангуулна. | Стандарт, БНбД-ийн дагуу бохир усны худаг, шугамын холболт хийсэн барилгын тоо | 20 | - | III | I/02 | УСУГ ОНӨААТҮГ | Хувийн хэвшил | XII |
| 6 | Хөрсний усны нэвчилттэй бохир усны худгуудыг засварлаж стандарт хангуулах | Засварласан худгийн тоо | 4 | 83.8 | V | I | УСУГ ОНӨААТҮГ | - | XII |
| 7 | Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн лаг хагшаасыг цэвэрлэж үерийн ус чөлөөтэй нэвтрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. | лаг хагшаасын хэмжээ | 32308 м3 | 1,410.0 | V/01 | X/30 | ГУББГ | - | XI/15 |
| 8 | Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн анхааруулах самбар байрлуулах. | Самбарын тоо | 50ш | 15.0 | VI/01 | VII/01 | ГУББГ | - | XI/15 |
| 9 | Үерийн эрсдэлтай бүсэд үерийн хамгаалалтын барилга байгууламж барих Жаргалантын үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барих | Байгууламжийн урт | 150м | 300.0 | VIII/01 | IX/01 | ГУББГ | - | XI/15 |
| 10 | Авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажлын байршилд норм стандартын шаардлага хангасан угсралтын ажлыг гүйцэтгэнэ. | Шурамын урт | 1566м | 1500.0 | V/01 | X/30 | ГУББГ | - | XI/15 |
| 11 | ХУД 18-р хороо Зайсангийн гудамжны борооны ус зайлуулах шугамын холболтын ажил (Гэгээнтэн цогцолбор) | Шурамын урт | 270 М | 350.0 | V/01 | X/30 | ГУББГ | - | XI/15 |
| 12 | Авто замын борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээ, арчлалтын ажлыг хийх гүйцэтгэнэ | лаг хагшаасын хэмжээ | 3000 м3 | 1540.0 | V/01 | X/30 | ГУББГ | - | XI/15 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний засвар арчлалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. | Шурамын урт | 18.3 км | 60 | V/01 | X/30 | ГУББГ | - | XI/15 |
| 14 | Хөрсний усны мониторингийн цооногийн ашиглалтын хэвийн ажиллагааг хангана. | Цооногийн тоо | 45ш | 105 | V/01 | X/30 | ГУББГ | - | XI/15 |
| 15 | Насос санцын тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах | Насос станцын тоо | байнга | 380 | I/01 | XII/31 | ГУББГ | - | XI/15 |
| 1.5. Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, аюулгүй байдал | | | | | | | | | |
| 1 | Сургууль, цэцэрлэгийн орчин болон хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдалд хяналт шалгалт хийж, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 1 | 2.0 | V/01 | VII/01 | ХУД ЗДТГ | БХ, хороод, СӨХ | IX/01 |
| 2 | Сургууль, цэцэрлэгийн гадна талбайг тохижуулж, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | сургууль, цэцэрлэгийн тоо | 5 | 1,952.0 /ДТХО/ | IV/15 | XI | ХУД ЗДТГ БНДЗДТГ | - | XI/01 |
| 3 | Бага сургууль цэцэрлэгийн цогцолборын барилга /БНД 3-р хороо/ | сургууль цэцэрлэгийн цогцолбор | 1 | 3,500.0 | IV | IX | НХОГ | БНДЗДТГ | XII/20 |
| 1.6. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | | | | | | | | |
| 1 | Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж буй газрын судалгааг гарган тэдгээрийг /MNS6423:2013/ стандартыг хангасан камерын хяналтад авах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах. | Гадна телехяналтын камерын систем | - | Үйл ажиллагаа ны зардлаар | III | XII | НЦУГ | МШУТ Дүүргийн цагдаагийн хэлтсүүд | XII |
| 2 | Нийслэлийн хэмжээнд Камерын стандартын хэрэгжилтийг хангуулна | Камерын стандартын шаардлагыг хангасан хорооны орчин | 300 | 300.0 | V | XII | НЦХМТГ | - | XII/31 |
| 3 | Нийслэлийн 9 дүүргийн гудамжинд Агаарын шилэн кабелийн стандартын хэрэгжилтийг хангуулна | Шилэн кабель татсан гудамжны тоо | 4 | 100.0 | IV | X | НЦХМТГ | | X/31 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7. Худалдан авах ажиллагаа | | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 18-26 дугаар тогтоолоор батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны тэгш өрсөлдөх зарчимд нийцүүлэн Тендерийн баримт бичигт холбогдох стандартуудын ерөнхий болон тусгай шаардлагыг тусгаж өгөх | Тендерийн баримт бичигт хотын стандартын ерөнхий шаардлагыг тусгасан байх | Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ бүрт | - | I/01 | XII/31 | НХААГ, нийслэл, дүүргийн Худалдан авах ажиллагаа зохион байгуулж буй байгууллагууд, | Захиалагчид хяналт тавих болон ашиглагч байгууллагууд | XII |
| 1.8. Худалдаа үйлчилгээний чиглэлээр | | | | | | | | | |
| 1 | "Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандартын хэрэгжилтийг хангуулах | Стандартын шаардлага хангасан зочид буудлын тоо | 260 | 25,000.00 | VI/01 | V/31 | НАЖГ | УБЗАА, НЦУГ, НОБГ, НХХААГ, ХСХГ, ДЗДТГ, МЗБХ, | VIII/25 |
| 2 | "Аялал жуулчлал. Дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандартын хэрэгжилтийг хангуулах | Стандартын шаардлага хангасан дэн буудлын тоо | 240 | 24,000.00 | V/01 | VI/30 | НАЖГ | УБЗАА, НЦУГ, НОБГ, НХХААГ, ХСХГ, ДЗДТГ, Дэн буудал эрхлэгчдийн "Өргөө" холбоо | VIII/25 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | “Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандартын хэрэгжилтийг хангуулах | Стандартын шаардлага хангасан амралтын газар, жуулчны баазын тоо | 190 | 15,000.00 | V/01 | VII/31 | НАЖГ | УБЗАА, НЦУГ, НОБГ, НХХААГ, ХСХГ, ДЗДТГ, Жуулчны баазуудын холбоо | VIII/25 |
| 4 | “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013” стандартын хэрэгжилтийг хангуулах | Стандартын шаардлага хангасан эко аялал жуулчлалын зориулалттай байр сууцны тоо | 190 | 15,000.00 | V/01 | VII/31 | НАЖГ | УБЗАА, НЦУГ, НОБГ, НХХААГ, ДЗДТГ, МЗБХ | VIII/25 |
| 5 | “Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага UCS1203:2020” хотын стандартын хэрэгжилтийг хангуулах | Стандартын шаардлага хангасан тохижилттой байгууллагуудын тоо | 190 | 15.00 | V/01 | VII/31 | НАЖГ | УБЗАА, НЦУГ, НОБГ, НХХААГ, ДЗДТГ, Жуулчны баазуудын холбоо | VIII/25 |
| 6 | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн аж ахуйн нэгжүүдэд “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” болон “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандартын дагуу зөвлөмж бэлтгэн хүргүүлэх | Стандартын шаардлага хангасан тохижилттой байгууллагуудын тоо | 190 | - | III/15 | IV/03 | НАЖГ, НБОГ | УБЗАА, ХСХГ | VIII/25 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Худалдаа, үйлчилгээний газрын гадна хаяг, зар сурталчилгааны байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэх. | ААНБ-ын тоо | 16289 | | III/15 | XI/15 | УБЗАА, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | ХСХГ | XII/01 |
| 8 | Худалдаа, үйлчилгээний байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх талбайн гэрэлтүүлгийг сайжруулах, нийт аж ахуйн нэгжийн 10-аас доошгүй хувийг стандартын шаардлага хангуулах ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 1 | - | V/15 | I/25 | УБЗАА, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | Хороод | X/30 |
| 9 | Худалдаа, үйлчилгээний болон төрийн бүх шатны байгууллагуудын орчны 50м зураглал хийлгэж баталгаажуулах, тэдгээрийг тохижуулах, цас, хог цэвэрлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах. | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 1 | - | V/15 | I/25 | УБЗАА, ХСХГ, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | Хороод | X/30 |
| 10 | Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний газруудын гадна орчны цэвэрлэгээ, тохижилт, ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах цэгийн стандартыг хангуулж ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 1 | - | III/15 | I/15 | УБЗАА, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | Хороод | X/30 |
| 11 | Худалдааны байгууллагуудад үйлчилгээний болон гадна орчны стандартын хэрэгжилтийг хангуулна. | Үйлчилгээний стандарт хангасан газрын тоо | 50 | 0,33 | IV | XII | УБЗАА, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | НЭМГ, НХХААГ | XII/01 |
| 12 | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад үйлчилгээний болон гадна орчны стандартын хэрэгжилтийг хангуулна. | Үйлчилгээний стандарт хангасан газрын тоо | 50 | 0,33 | IV | XII | УБЗАА, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | НЭМГ, НХХААГ | XII/01 |
| 13 | Хүнсний үйлдвэрийн хүнсний нийлэг сав баглаа боодлын стандартын хэрэгжилтийг хангуулна | Хаяг шошгын стандарт хангагдсан үйлдвэрийн тоо | 10 | - | VI | XII | УБЗАА, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | НХХААГ | XII/01 |
| Хоёр. Сургалт | | | | | | | | | |
| 1 | Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан | Зохион байгуулсан | 9-оос доошгүй. | - | III/01 | I/01 | ХСХГ ДЗДТГ | Хороод | X/01 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | таниулах, сургалт арга зүйгээр хангахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллана. | арга хэмжээ, тоо | | | | | | Иргэд, ААНБ | |
| 2 | Стандарт, норм, дүрмийн талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг төлөвшүүлж сурталчлах ажлыг байгууллагын үйл ажиллагаа, арга хэмжээтэй холбон зохион байгуулна. | "Зохион байгуулсан ажил | | - | IY/01 | IX/20 | НЗДТГ | УБЗАА, НЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагууд, ДЗДТГ | XII/25 |
| 3 | Зураг төсөл зохиогч байгууллагууд, дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч ААН, барилгын угсралт, буулгалт, ашиглалтын үеийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, ААН-д хууль тогтоомж, норм дүрэм, стандартыг мөрдөж ажиллах талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | Хамрагдсан ААН тоо | 157 | 40.00 | III/15 | IX/30 | ХСХГ | ДЗДТГ | XI/15 |
| 4 | Нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч, худалдан авах ажиллагааны газар, гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан компанид сургалт зохион байгуулах. | Хамрагдсан ААН тоо | 28 | - | III/15 | V/01 | УБЗАА, | НХААГ, НХОГ, ХСХГ ДЗДТГ, | V/15 |
| 5 | Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөний төсөлд Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулах зөвлөмж, мэдээлдлийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна. | Зөвлөмжийн тоо | 1 | - | VI/01 | XI/10 | ХСХГ | ХБХГ | XI/15 |
| 6 | Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд хот байгуулалтын БНбД, стандарт мөрдүүлж, зөвлөмж, арга зүйгээр хангаж ажиллана. | ААН-ын тоо | 27 | - | III/15 | XI/10 | ХБХГ | ХСХГ, НОСБГ | XI/15 |
| 7 | Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хий, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэн, хуулийн этгээдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлнэ. MNS | Олон нийтийн оролцоог хамарсан арга хэмжээний тоо. | 2 | 230.00 | II/01 | XII/15 | НАОБТГ | - | XII/15 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартыг мөрдөж ажиллана. | | | | | | | | |
| 8 | “Барилгын хог хаягдлын менежмент”, “Аюултай хог хаягдлын менежмент” хотын стандартыг сурталчлан таниулах, зөвлөмж хүргүүлэх. | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | - | III/15 | XI/15 | ХСХГ | УБЗАА, НБОГ | XII/01 |
| 9 | Хөрсний бохирдол үүсгэж байж болзошгүй аж ахуйн нэгжүүдэд стандартын шаардлага хууль, эрх зүйн орчны талаарх сургалт мэдээлэл хийх | Сургалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн төлөөллийн тоо | 300 | - | IV/25 | IV/25 | НБОГ, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ | ХСХГ | VII/01 |
| 10 | Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилга (ашиглалт)-д хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй төлөвлөлтийн стандартыг хангуулах мэдэгдэл, зөвлөмж хүргүүлнэ. | Зөвлөмж хүргүүлсэн байгууллагын тоо | 890 | - | VI/01 | XI/10 | ХСХГ | ННЗБ, ДЗДТГ | XI/15 |
| 11 | Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах халаалтын зуухны техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны талаар инженер техникийн албан хаагч нарт “Бага хүчин чадлын зуухны техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн сургалт зохион байгуулах. | Хамрагдсан ААН-ын тоо | 18 | - | III/15 | XI/15 | ХСХГ, УБЗАА | ХИХУГ | XII/01 |
| 12 | Жижиглэнгээр /220 грамм/ савласан шингэрүүлсэн шатдаг хийн аюулгүй хэрэглээ, зохисгүй хэрэглээнээс гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг худалдаа эрхлэгч байгууллага, хүүхдийн байгууллагуудад зохион байгуулах. | Хамрагдсан ААН-ын тоо | 60 | - | III/15 | XI/15 | ХСХГ, УБЗАА | УУХҮЯ, НЦУГ, Хийн хангамжийн инженерийн нийгэмлэг ТББ | XII/01 |
| 13 | Хүчилтөрөгчийн хийн баллонт тоног төхөөрөмж хэрэглэгч эмнэлгийн байгууллагуудын инженер техникийн ажилтнуудад “Даралтат савыг төхөөрөмжлөх. Аюулгүй ашиглах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулах сургалтыг зохион байгуулах. | ААН-ын тоо | 20 | - | III/15 | XI/15 | ХСХГ, НЭМГ | УУХҮЯ, ЭМЯ | XII/01 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид шинээр батлагдсан болон одоо мөрдөгдөж буй стандартыг сурталчлан таниулах сургалт зохион байгуулах. | ААН-ын тоо | 20 | - | III/15 | XII/01 | ХСХГ | ХСХГ | XII/15 |
| 15 | Төрийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага UCS 1104B:2022 стандарт хангуулах сэдвээр сургалт зохион байгуулна. | Сургалтанд хамрагдсан байгууллагын тоо | 50 | байхгүй | III/28 | III/28 | СБД ЗДТГ-ын Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс | ХСХГ | |
| Гурав. Судалгаа | | | | | | | | | |
| 1 | Хот, суурин газрын инженерийн бэлтгэл арга хэмжээнд тандалт судалгаа хийх. | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100% | - | VI/01 | XI/01 | ХСХГ | УСУГ, ГУББГ | XI/15 |
| 2 | Орон сууцны барилгын ашиглалтын төлөв байдалд тандалт судалгаа хийж, | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100% | - | III/15 | V/01 | ХСХГ | НОСБГ, ДЗДТГ, СӨХ-ны дээд зөвлөл | XI/15 |
| 3 | Орон сууцны барилгын паспортжуулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100% | - | III/15 | V/01 | ХБХГ | - | XI/15 |
| 4 | Орон сууцны инженерийн шугам сүлжээний ашиглалтын төлөв байдалд тандалт судалгаа хийх. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | - | III/15 | XI/01 | ХСХГ | УБЦТС ТӨХК, УБДС ТӨХК, УСУГ ОНӨААТҮГ МХС ТӨХК | XI/15 |
| Дөрөв. Хяналт шалгалт | | | | | | | | | |
| 4.1 Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт | | | | | | | | | |
| 4.1.1. Барилга | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Стандартын шаардлага хангахгүй, эрсдэлтэй амралт, хүүхдийн тоглоомын талбайд хяналт шалгалтыг дүүрэг бүрээр зохион байгуулж, “MNS 6751:2019 Хүүхдийн тоглоомын талбай” стандарт, “UCS1405B:2022 Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандартыг мөрдүүлэх чиглэлээр эзэмшигч, ашиглагч байгууллагуудад зөвлөмж, мэдэгдэл хүргүүлнэ. | Тоглоомын талбайн тоо | 487 | 1.00 | III/15 | XI/01 | ХСХГ | Төвийн 6 дүүргийн ЗДТГ | XI/15 |
| 2 | Барилгын угсралтын үеийн үйл ажиллагаанд орчны аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт тавьж, “UCS 0301B:2022 Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага” хотын стандартыг мөрдүүлнэ. | Хамрагдсан ААН тоо | 400 | - | III/15 | XII/01 | ХСХГ | ДЗДТГ | XI/15 |
| 3 | Хүнсний томоохон үйлдвэрүүдийн бохир ус зайлуулах системд холбогдох газруудтай хамтран урьдчилан сэргийлэх хяналт хийнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100% | - | VI/01 | VI/01 | ХСХГ | НЭМГ, НХХААГ, НБОГ | VII/01 |
| 4 | Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлагыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, аж ахуйн нэгж байгуулагуудад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | - | I/ | XII/ | ХСХГ, “Улаанбаатар лифт” НӨҮГ | - | XII/25 |
| 5 | Барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй барилга, байгууламжийг албадан буулгах арга хэмжээний санал, мэдээллийг БХБЯ-нд хүргүүлэх. | Саналын тоо | 1 | - | III/15 | XI/01 | ХБХГ, ХСХГ | НЗДТГ | XI/15 |
| 4.1.2. Дэд бүтэц | | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн хэмжээнд шинээр хийгдэх болон ашиглагдаж байгаа нийтийн эзэмшлийн гадна гэрэлтүүлгийн зураг төсөл, баримт бичиг, угсралт, ашиглалтад Эрчим хүчний тухай хууль, Цахилгаан байгууламжийн дүрэм, Эрчим хүч хэрэглэх дүрэм, Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлага UCS 1901B, Гэрэлтүүлэх төхөөрөмжийг төлөвлөх, байрлуулах, суурилуулах удирдамж UCS 1902A | Объектын тоо | 8 | - | III/15 | XII/01 | ХСХГ | УБЗАА | XII/15 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зэрэг норм стандартын хэрэгжилт хангагдаж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | | | | | | | | |
| 2 | Дулааны шугам сүлжээ, түүний хамгаалалтын бүс зөрчин үйл ажиллагаа явуулж буй иргэн аж ахуй нэгж байгууллагуудад Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн мөрдөлт хангагдаж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | Хамгаалалтын зурвасын зөрчлийн тоо | 9 | - | III/15 | XII/01 | ХСХГ | Улаанбаатар дулааны сүлжээ | XII/15 |
| 3 | Нийтийн эзэмшлийн зам талбайд хийгдэж байгаа хяналтын камерын зураг төсөл, баримт бичиг, угсралтын ажилд болзошгүй эрсдэл, техникийн аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх хяналт хийх. | төсөл, арга хэмжээний тоо | 5 | - | III/15 | XI/15 | ХСХГ | НЦХМТГ, НЦУГ, НЗХУТ | XII/01 |
| 4 | Нийслэлд аюултай хог хаягдал /ашиглалтын хугацаа дууссан автомашины аккумлятор, батарей, ашигласан тос, масло/ худалдан авч буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | Иргэн, аж ахуй нэгжийн тоо | 20 | - | III/15 | XI/15 | ХСХГ | ЗТХЯ, УБЗАА, НБОГ | XII/01 |
| 5 | Шинээр баригдаж байгаа авто зам, замын байгууламжийн зураг төслийн боловсруулалт, инженерийн бэлтгэл ажил, барилга угсралтын ажлын чанар, аюулгүй байдалд Авто замын тухай хууль, "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага" ЗЗБНбД 31-008-2016-ийн 112, МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол, UCS 0901B Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага, UCS 0903B Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлагын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | төсөл, арга хэмжээний тоо | 6 | - | III/15 | XII/01 | ХСХГ | ЗТХЯ, НЗХГ, ДЗДТГ | XII/15 |
| 6 | Байгаль орчны яамны орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны захиалгаар улсын төсвөөр хийгдсэн сургууль, цэцэрлэгийн цогцолборын нам даралтын зуухыг эрчим хүчний хэмнэлттэй хийн зуухаар сольж | Нам даралтын зуухны тоо | 8 | - | III/15 | XII/01 | ХСХГ | Захиалагч, ХИХУГ | XII/15 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суурилуулсан ажлын гүйцэтгэл, ашиглалт, аюулгүй ажиллагааны байдалд “Хийн хангамж” БНбД, “Эрчим хүчний тухай” хуулийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх. | | | | | | | | |
| 7 | Хийн баллон ашиглаж байгаа нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг ААНБ-ын аюулгүй байдлыг хангуулах | Иргэн, аж ахуй нэгжийн тоо | 140 | - | VI/01 | XI/01 | ХСХГ | УБЗАА, НХХААГ, НОБГ, ДЗДТГ | XI/15 |
| 4.1.3 Гэр бүл, хүүхэд хамгаалал | | | | | | | | | |
| 1 | “Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа”, Ерөнхий шаардлага MNS5633:2019” стандартын хэрэгжилтийг хангуулуулах хяналт шалгалтын ажил зохион байгуулна. | Хяналт шалгалтын тоо | 1 | 5.000,0 | VI | VIII | НГБХЗХГ | НОБГ НЭМГ НЦГ | |
| 2 | “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS6781:2019” стандартын хэрэгжилтийг хангуулуулах хяналт шалгалтын ажил зохион байгуулна. | Хяналт шалгалтын тоо | 1 | 1.000,0 | VIII | IX | НГБХЗХГ | НБГ | |
| 3 | “Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6540:2015/ стандартын хэрэгжилтийг хангуулуулах хяналт шалгалтын ажил зохион байгуулна. | Хяналт шалгалтын тоо | 1 | 3.000,0 | VIII | I/01 | НГБХЗХГ | НОБГ НЦГ | |
| 4 | “Үндэсний морин уралдааны морь уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS62645:2018” стандартын хэрэгжилтийг хангуулуулах хяналт шалгалтын ажил зохион байгуулна. | Хяналт шалгалтын тоо | 3 | 16.000,0 | V | IX | НГБХЗХГ | НЗДТГ НОБГ НЦГ | |
| 5 | “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040: 2019” стандартын хэрэгжилтийг хангуулуулах хяналт шалгалтын ажил зохион байгуулна. | Хяналт шалгалтын тоо | 1 | 1.000,0 | IV | X | НГБХЗХГ | НЭМГ НЦГ | |
| 6 | “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852: | Хяналт шалгалтын тоо | 2 | 1.000,0 | VI | I/01 | НГБХЗХГ | НХХГ | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2017“ стандартын хэрэгжилтийг хангуулуулах хяналт шалгалтын ажил зохион байгуулна | | | | | | | | |
| 4.1.4 Байгаль орчин | | | | | | | | | |
| 1 | Авто засварын газрын гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага, Авто машин угаалгын газарт тавигдах ерөнхий шаардлагын хэрэгжилтийг хангуулах хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах | Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо | 495 | 2.5 | V/01 | VIII/01 | Нийслэлийн Байгаль орчны газар | Хотын стандарт, хяналтын газар, | IX/01 |
| 2 | Зах үйлчилгээний төвүүдийн гадна талбайд тавигдах шаардлагын хэрэгжилтэд хийх хамтарсан хяналт шалгалт | Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо | 200 | 2.5 | V/01 | VIII/01 | Нийслэлийн Байгаль орчны газар | Хотын стандарт, хяналтын газар, | IX/01 |
| 4.2. Төлөвлөгөөт хяналт шалгалт | | | | | | | | | |
| 4.2.1. Барилга | | | | | | | | | |
| 1 | Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн барилгын угсралтын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | Хамрагдсан ААНБ-ын тоо | 81 | - | III/15 | XI/01 | ХСХГ | Холбогдох Хяналтын чиг үүрэг бүхий байгууллагууд | XI/15 |
| 2 | Барилгын зураг төслийн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | Хамрагдсан ААНБ-ын тоо | 27 | - | III/15 | XI/15 | ХСХГ | - | XI/15 |
| 3 | Усан хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | Хамрагдсан ААНБ-ын тоо | 27 | - | III/15 | XI/15 | ХСХГ | Холбогдох Хяналтын чиг үүрэг бүхий байгууллагууд | XI/15 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Бетон зуурмаг, төмөр бетон зуурмаг, цонх үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | Хамрагдсан ААНБ-ын тоо | 18 | - | III/15 | XI/15 | ХСХГ | - | XI/15 |
| 5 | Өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | Хамрагдсан ААНБ-ын тоо | 18 | - | III/15 | XI/15 | ХСХГ | Холбогдох Хяналтын чиг үүрэг бүхий байгууллагууд | XI/15 |
| 4.2.2. Дэд бүтэц | | | | | | | | | |
| 1 | Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.13 заалтын дагуу Эрчим хүчний дэд станц, шугам тоноглолыг үе шаттайгаар мэргэжлийн эрх бүхий байгууллагад шилжүүлэхэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | шилжүүлсэн объектын тоо | 6 | - | III/15 | XII/01 | ХСХГ | Тусгай зөвшөөрөлтэй ААНБ | XII/15 |
| 2 | Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах халаалтын зуухны техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангуулахад Эрчим хүчний тухай хууль, Бага хүчин чадлын зуухны техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилтэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | Объектын тоо | 9 | - | III/15 | XII/01 | ХСХГ | - | XII/15 |
| 3 | Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээ, кабелийн угсралтын ажилд MNS6668:2017, MNS 4908:2017 стандартын дагуу зураг төсөл, баримт бичиг, угсралтын ажилд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | Объектын тоо | 5 | - | III/15 | XII/01 | ХСХГ | - | XII/15 |
| 4 | Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн асфальтобетон үйлдвэрүүдийн үйл ажиллагаа болон материалын орц найрлагад асфальтбетон заводуудад Авто замын тухай | ААН-ын тоо | 9 | - | III/15 | XII/01 | ХСХГ | - | XII/15 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн хэрэгжилтийг хангуулахаар төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | | | | | | | | |
| 5 | Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийдэг аж ахуй нэгжүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | ААН-ын тоо | 12 | - | III/15 | XII/01 | ХСХГ | ЗТХЯ | XII/15 |
| 6 | Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн ШТС, АХЦС-уудын аюулгүйн зай хэмжээ, шатахуун болон шингэрүүлсэн шатдаг хий хадгалах савнуудын техникийн бүрэн бүтэн байдалд "Газрын тосны бүтээгдэхүүний тухай" хуулийн 9.3.5, 11.2.3, 11.2.6, 11.3, 11.4.2, "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм. БНбД 30-01-04-ийн 6.39 заалт, "Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм БНбД 21-07-14-ийн 5.8 заалтуудын хэрэгжилтэд төлөвлөгөөт шалгалт хийх. | ШТС, АХЦС-ын тоо | 9 | - | III/15 | XII/01 | ХСХГ | ХБХГ, НГЗБА, НОБГ | XII/15 |
| 4.2.3 Агаарын чанар | | | | | | | | | |
| 1 | Ердийн галлалгаатай 3кВт-15кВт, уурын болон усан халааттай 15кВт-100кВт, 100кВт-4200кВт хүртэлх хүчин чадалтай зуух ашиглагч, дулаан, цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж стандарт мөрдүүлэх. Үүнд:<br>1. MNS 5086:2001 уурын зуух Нэр томьёо тодорхойлолт<br>2. MNS 5216:2016 ахуйн хэрэглээний зуух Техникийн ерөнхий шаардлага/<br>3. MNS 5043:2016 4.2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага<br>4. MNS 5919:2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар | Стандартад нийцсэн уурын болон цахилгаан зуух ашигласан ИАННБ-ын тоо | 160 | 20.00 | III/15 | XII/15 | НАОБТГ | - | XII/15 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга | | | | | | | |
| 2 | Авто замын хөдөлгөөнд оролцож буй нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт хийж, стандартад нийцүүлэх арга хэмжээ авна.<br>1. MNS 5013 : 2009 Бензин хөдөлгүүртэй автомашины утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга<br>2. MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга | Хаягдал утааны агууламжийг тодорхойлох хяналт шалгалт хийсэн тээврийн хэрэгслийн | 450 | - | III/15 | XII/15 | НАОБТГ | - | XII/15 |
| 4.3 Төлөвлөгөөт бус хяналт шалгалт | | | | | | | | |
| 1 | Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хийнэ. | Албан бичиг, өргөдөл гомдлын тоо | | - | I/02 | XII/31 | ХСХГ | Холбогдох байгууллага | XII/31 |
| 4.4 Гүйцэтгэлийн хяналт шалгалт | | | | | | | | |
| 1 | Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулана. | Хяналт шалгалтын тоо | 524, Төлөвлөгөөт бус хяналт тоо | - | I/02 | XII/31 | ХСХГ | Холбогдох байгууллага | XII/31 |